АЖЛЫН БАЙРНЫ ЗАР · 2026 оны 9-р сарын 15

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ СУЛ ОРОН ТООНЫ ЗАР



Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах хүсэлтэй төрийн жинхэнэ албан хаагчийг Улсын ерөнхий прокурорын газрын "Дотоод ажил хариуцсан референт"-ын албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Нэг.Тавигдах болзол, шаардлага:

1.1.Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;

1.2.Зарлаж буй албан тушаалтай адил төрөл, адил ангилалд ажилладаг байх;

1.3.Зарлагдсан сул орон тооны албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаалын нэр	Албан тушаал		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
			Ангилал	Зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
Улсын ерөнхий прокурорын газар	Хэрэг эрхлэх газар	Дотоод ажил хариуцсан референт	Ахлах түшмэл	АА-6	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	- Эрх зүйч /0421/; - Менежмент ба удирдахуй /041303-041305/.	Төрийн албан хаагчийн дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дээш түшмэлийн албан тушаалд 3-өөс доошгүй жил ажилласан байх

Хоёр.Бүрдүүлэх материал

2.1.Хүсэлт;

2.2.Төрийн албан хаагчийн анкет (ТАЗ-ийн 2025 оны 521 дүгээр тогтоолын 1-р хавсралтын дагуу);

2.3.Иргэний үнэмлэхийн хуулбар;

2.4.Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг (диплом), хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;

2.5.Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;

2.6.Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, цахим лавлагаа;

2.7.Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;

2.8.Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;

2.9.Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;

2.10.Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх;

2.11.Сахилгын шийтгэлтэй эсэх тодорхойлолт;

2.12.Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (E-Mongolia–гаас татаж авах).

Гурав. Материалыг 2026 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 17:00 цаг хүртэл, hrm@prosecutor.mn цахим шуудангийн хаягаар хүлээн авна.

Дэлгэрэнгүй мэдээллийг 51-260855 дугаарын утсаар холбогдож авна уу.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/390